
МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ
ГЭМТ ЭТГЭЭДИЙГ ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД
АРД УЛС ХООРОНДЫН ГЭРЭЭ

1997 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Улаанбаатар хотноо

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс /цаашид “Талууд” гэнэ/, бие биеийн бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэж, эрх тэгш, харилцан ашигтай байх үндсэн дээр гэмт этгээд шилжүүлэн өгөх талаархи эрх зүйн хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэн дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх үүрэг

Талууд энэхүү Гэрээний заалтын дагуу эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор аль нэг Талын нутаг дэвсгэрт илэрсэн болон нөгөө Талын хуулийн эрх бүхий багууллагаас эрэн сурвалжлагдаж буй этгээдийг аль нэг Талын зохих ёсны хүсэлтийн дагуу бие биедээ шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ.

2 дугаар зүйл

Гэмт этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэрэг

1.Энэхүү Гэрээний зорилгоор гэмт этгээдийг шилжүүлбэл зохих гэмт хэрэг гэдэг нь Талуудын хууль тогтоомжийн дагуу нэг жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл өр хүнд ял оногдуулах гэмт хэргийг хэлнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцлөөр шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь шүүхийн таслан шийдвэрлэх тогтол биелүүлэхтэй холбогдолтой бөгөөд уг тогтоолоор оногдуулсан ялын үлдсэн хугацаа нь 6 сараас дээш бол гэмт этгээдийг шилжүүлэн өгнө.

3.Энэ зүйлийн зорилгоор гэмт хэргийг хоёр Талын хууль тогтоомжийг зөрчсөн гэмт хэрэг болох эсэхийг тогтооход аль нэг Талын хууль тогтоомжоор гэмт хэргийг бүрдүүлж буй үйлдэл, эс үйлдлийг хуулийн нэг зүйлээр зүйлчилж, эсхүл нэг нэр томъёогоор

тодорхойлж буй эсэхийг үл харгалзана.

4.Хэрэв шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь хэд хэдэн гэмт хэргийг хамарч буй бөгөөд тэдгээр нь Талуудын хууль тогтоомжийн дагуу бүгд шийтгэгдвэл зохих гэмт хэрэг боловч зарим нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан бусад нөхцөлтэй нийцэхгүй бол тухайн этгээдийн үйлдсэн шилжүүлбэл зохих нэгээс доошгүй гэмт хэрэгт нь холбогдуулан шилжүүлэн өгч болно.

3 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэл

Дараах тохиолдолд гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй. Үүнд:

1/Эрэн сурвалжлагдаж буй этгээд нь хүсэлт хүлээн авагч Талын иргэн бол;

2/Эрэн сурвалжлагдаж буй этгээдэд хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу улс төрийн орогнол олгосон бол;

3/Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь эрэн сурвалжлагдаж буй этгээдийг арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харъяалал, хүйс, эсхүл улс төрийн үзэл бодлоор нь ял шийтгэх гэж байгаа, эсхүл шүүн таслах ажиллагааны үеэр дээрх шалтгаанаар хохироох бодитой үндэслэлтэй гэж хүсэлт хүлээн авагч Тал үзсэн бол;

4/Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд дурдсан гэмт хэрэг нь хүсэлт гаргагч Талын хууль тогтоомжийн дагуу зөвхөн цэргийн гэмт хэрэгт хамаардаг бол;

5/Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, өршөөгдсөн зэрэг эрх зүйн үндэслэлээр шилжүүлэн өгөхийг хүссэн этгээдийг эрүүгийн хариуцлага, эсхүл ял шийтгэлээс чөлөөлсөн бол;

6/Эрэн сурвалжлагдаж буй этгээдийн үйлдсэн шилжүүлэн өгөх гэмт хэргийн талаар хүсэлт хүлээн авагч Талын эрх бүхий байгууллагаас шүүхийн шийдвэр гаргасан, эсхүл энэ хэргийг хэрэгсэхгүй болгосон бол.

4 дүгээр зүйл

Шилжүүлэн өгөхөөс татгалзаж болох үндэслэл

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхийг дараах



тохиолдолд татгалзаж болно. Үүнд:

1/Шилжүүлэн өгөхийг хүссэн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг нь хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу тухайн улсын шүүн таслах харъяалалд хамаардаг бол;

2/Шилжүүлэн өгөхийг хүссэн этгээдийн эсрэг хүсэлт хүлээн авагч Тал тухайн шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэрэгтэй нь холбогдуулан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа бол.

5 дугаар зүйл

Хүсэлт хүлээн авагч Тал эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг

Энэхүү Гэрээний 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзсан бол хүсэлт хүлээн авагч Тал тухайн эрэн сурвалжлагдаж буй этгээдийг мөрдөн байцаах, ял шийтгэх зорилгоор өөрийн эрх бүхий байгууллагад хүсэлт гаргагч Талын хүсэлтээр шилжүүлэн өгнө. Хүсэлт гаргагч Тал эл зорилгоор хүсэлт хүлээн авагч Талд хэргийн холбогдох баримт бичиг, эд мөрийн баримтыг шилжүүлнэ.

6 дугаар зүйл

Харилцах суваг

Энэхүү Гэрээний зорилгоор хэрэв өөрөөр заагаагүй бол Талууд тус тусын томилсон эрх бүхий байгууллагаар дамжин харилцана. Талууд дипломат шугамаар харилцаж болно.

7 дугаар зүйл

Харилцах хэл

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэхдээ Талууд тус бүрийн улсын албан ёсны хэлийг хэрэглэх бөгөөд нөгөө Талын улсын албан ёсны хэл, эсхүл англи хэлээрх орчуулгыг хавсаргана.

8 дугаар зүйл

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт болон түүнд шаардагдах баримт бичиг

1.Шилжүүлэн өгөх хүсэлтийг бичгээр гаргаж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана.

Үүнд:

1/хүсэлт гаргаж буй эрх бүхий байгууллагын нэр;

2/эрэн сурвалжлагдаж буй этгээдийн овог



нэр, иргэний харъяалал, байнга оршин суудаг газар, хаяг, тухайн этгээдийн талаархи бусад мэдээ, боломжтой бол түүний гадаад төрхийн талаархи тодорхойлолт, гэрэл зураг, хурууны хээ;

3/тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг болон түүний улмаас учирсан хор уршгийн талаархи товч тодорхойлолт;

4/тухайн гэмт хэрэг болон түүнд оногдуулах ял шийтгэл, түүнчлэн уг хэргийг хөөн хэлэлцэх хугацаа зэргийг заасан хууль тогтоомжийн холбогдох заалтуудын ишлэл.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгээс гадна гэмт этгээдийг шилжүүлэн өгөхийг хүссэн хүсэлтэд эрэн сурвалжлагдаж буй этгээдийг хүсэлт гаргагч Талын эрх бүхий байгууллагаас баривчлахыг зөвшөөрсөн зөвшөөрлийн хуулбар.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгээс гадна эрэн сурвалжлагдаж буй этгээдэд оногдуулсан ял эдлүүлэхтэй холбоотой дараах баримт бичгийг гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд хавсаргана. Үүнд:

1/шүүхийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоол, эсхүл магадлалын хуулбар;

2/ял эдэлсэн хугацааны тодорхойлолт.

4.Энэхүү Гэрээний дагуу хүсэлт гаргагч талын бүхий л баримт бичигт албан ёсны гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байна.

5.Энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгөх тухай хүсэлт, бусад баримт бичгийн эх хувь буюу тэдгээрийн баталгаатай хуулбарыг дахин баталгаажуулах шаардлагагүй.

9 дүгээр зүйл

Нэмэлт мэдээлэл

Хүсэлт хүлээн авагч Тал нь гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлттэй холбоотой мэдээллийг энэхүү Гэрээний шаардлагыг хангахгүй байна гэж үзвэл нэмэлт мэдээлэл хүсч болно. Хүсэлт гаргагч Тал энэ хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор энэхүү нэмэлт мэдээллийг гарган өгнө. хэрэв хүндэтгэх шалтгаан байвал энэ хугацааг дахин 15 хоног сунгаж болно. Хүсэлт гаргагч



Тал тухайн хугацаанд нэмэлт мэдээллийг өгч чадаагүй бол уг хүсэлтийг сайн дураараа цуцалсанд тооцож хүсэлт хүлээн авагч Тал эрэн сурвалжлагдаж буй этгээдийг суллаж болох бөгөөд энэ нь хүсэлт гаргагч Тал тухайн гэмт хэрэгтэй холбогдуулан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт дахин гаргахад саад болохгүй.

10 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхөөр баривчлах

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авагч Тал энэхүү Гэрээний заалтын дагуу гэмт этгээдийг шилжүүлэн өгөхгүй байх нөхцлөөс бусад тохиолдолд эрэн сурвалжлагдаж буй этгээдийг баривчилж цагдан хорих арга хэмжээг нэн даруй авна.

11 дүгээр зүйл

Урьдчилан баривчлах

1.Яаралтай тохиолдолд аль нэг Тал эрэн сурвалжлагдаж буй этгээдийг урьдчилан баривчлуулах хүсэлтийг гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт тавихын өмнө нөгөө Талд гаргаж болно. Ийм хүсэлтийг дипломат шугамаар, эсхүл Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагаар дамжуулан бичгээр тавина.

2.Ийм хүсэлтэд 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалтад заасан баримт бичиг, хүсэлт гаргагч Талын эрх бүхий байгууллагын баривчлах зөвшөөрлийн хуулбар, эсхүл цагдан хорих шийдвэрийн хуулбар, энэхүү Гэрээний 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан баримт бичиг болон нэн даруй шилжүүлэн өгөхийг хүссэн мэдэгдэл зэргийг хавсаргана.

3.Хүсэлт хүлээн авагч Тал нь энэхүү хүсэлтийн дагуу авсан арга хэмжээний талаар хүсэлт гаргасан Талд нэн даруй мэдэгдэнэ.

4.Баривчлагдсан этгээдийг цагдан хорьсон өдрөөс хойш 30 хоногийн дотор шилжүүлэн өгөх хүсэлт болон энэхүү Гэрээний 8 дугаар зүйлд заасан холбогдох баримт бичгийг хүсэлт хүлээн авагч Тал хүлээн аваагүй бол түүнийг суллана. Хүндэтгэх шалтгаан байвал энэхүү хугацааг хүсэлт гаргагч Талын



хүсэлтээр 15 хоног хүртэл сунгаж болно.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу баривчлагдсан этгээдийг суллан тавих нь хүсэлт хүлээн авагч Тал энэхүү Гэрээний 8 дугаар зүйлд дурдсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлт болон холбогдох баримт бичгийг гэмт этгээдийг сулласнаас хойш хүлээн авсан бол тухайн этгээдийг шилжүүлэн өгхөд саад болохгүй.

12 дугаар зүйл

Хүлээлгэн өгөхийг хойшлуулах

Эрэн сурвалжлагдаж буй этгээд нь хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт шилжүүлэн өгөхийг хүссэн гэмт хэргээс өөр гэмт хэрэгт холбогдон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шатанд байгаа, эсхүл ял эдэлж байгаа бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах буюу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг шилжүүлэн өгөх шийдвэр гаргасны дараа түүнийг хүлээлгэн өгөхийг хойшлуулж болно. Энэ тохиолдолд хүсэлт хүлээн авагч Тал энэ талаар хүсэлт гаргагч Талд мэдэгдэнэ.

13 дугаар зүйл

Хүсэлтийн талаархи шийдвэр

1.Хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг шилжүүлэн өгөх шийдвэр гаргасны дараа түүнийг хүлээлгэн өгөхийг хойшлуулж болно. Энэ тохиолдолд хүсэлт хүлээн авагч Тал энэ талаар хүсэлт гаргагч Талд мэдэгдэнэ.

13 дугаар зүйл

Хүсэлтийн талаархи шийдвэр

1.Хүсэлт хүлээн авагч Тал гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг өөрийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн хүсэлт гаргагч Талд энэ тухайгаа нэн даруй мэдэгдэнэ.

2.Хүсэлтийн бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан бол энэхүү үндэслэлээ заана.

14 дүгээр зүйл

Гэмт этгээдийг хүлээлгэн өгөх

1.Хүсэлт хүлээн авагч Тал гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай мэдэгдэл гаргасны дараа Талууд шилжүүлэн өгөх хугацаа, газар



зэргийг харилцан зөвлөлдөж тохирно.

2.Хүлээлгэн өгөхөөр тохиролцсон өдрөөс хойш 15 хоногийн дотор хүсэлт гаргагч Тал шилжүүлэн өгөх ёстой этгээдийг хүлээн аваагүй бол хүсэлт гаргагч Тал хүсэлтээ цуцалсан хэмээн үзэж хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээдийг суллана. Харин хүсэлт гаргагч Тал энэ гэмт хэрэгтэй холбогдуулан тухайн гэмт этгээдийг шилжүүлэн өгөх хүсэлт дахин гаргавал хүсэлт хүлээн авагч Тал татгалзаж болно.

3.Аль нэг Тал өөрөөс үл хамаарах шалтгаанаар товолсон хугацаанд тухайн этгээдийг шилжүүлэн өгөөгүй, эсхүл хүлээн аваагүй бол энэ тухайгаа нөгөө Талдаа нэн даруй мэдэгдэнэ. Талууд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлэн өгөх хугацаа, газар зэргийг харилцан зөвлөлдөж, дахин тохиролцоно.

15 дугаар зүйл

Эд зүйлс хүлээлгэн өгөх

1.Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн хүрээнд аль нэг гуравдагч талын хууль ёсны эрхийг хөндөхгүйгээр гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн эд мөрийн баримт болох эд зүйлс болон гэмт хэрэг үйлдэн олж авсан эд хөрөнгийг хүсэлт гаргагч Талын хүсэлтээр хүлээлгэн өгнө. Эрэн сурвалжлагдсан этгээд нас барсан, оргон зайлсан болон бусад аливаа шалтгаанаар шилжүүлэн өгч чадаагүй тохиолдолд ч дээр дурдсан эд зүйлс, эд хөрөнгийг хүлээлгэн өгнө.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйлс нь эрүүгийн өөр хэрэгт хэрэгцээтэй бол хүсэлт хүлээн авагч Тал тэдгээрийг буцаан өгөхийг түр хойшлуулж болно.

3.Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу, эсхүл гуравдагч талын эрхийг хамгаалах үүднээс хүлээлгэн өгсөн эд зүйлс болон эд хөрөнгийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дуусгавар болсны эцэст хүсэлт хүлээн авагч Тал хүсвэл үнэ төлбөргүй буцааж өгнө.

16 дугаар зүйл

Хэд хэдэн улсын хүсэлт



Аль нэг Тал болон аль нэг гуравдагч улс тухайн этгээдийг шилжүүлэн өгөхийг хүсвэл, хүсэлт хүлээн авагч Тал бүхий л нөхцөл байдал, ялангуяа гэмт хэргийн хүнд хөнгөн, үйлдэгдсэн газар, түүнчлэн эрэн сурвалжлагдаж буй этгээдийн иргэний харъяалал, байнга оршин суудаг газар, түүнийг дахин шилжүүлэн өгөх боломж болон шилжүүлэн өгөх тухай хүсэлт гаргасан хугацаа зэргийг харгалзан үзэж түүнийг чухам аль улсад шилжүүлэн өгөхийг шийдвэрлэж болно.

17 дугаар зүйл

Онцгой журам

1.Энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгсөн этгээдийг хүлээлгэн өгөхөөс өмнө үйлдсэн, шилжүүлэн өгөхийг хүссэн тухайн хэргээс өөр ямар нэг гэмт хэрэгт холбогдуулан хүсэлт хүлээн авсан Талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, ял шийтгэх болон тухайн этгээдийг гуравдагч улсад шилжүүлэн өгч болохгүй.

2.Хүсэлт хүлээн авсан Талын зөвшөөрөл дараах тохиолдолд шаардагдахгүй. Үүнд:

1/тухайн этгээд нь хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрийг орхин гарсны дараа сайн дураараа буцаж очсон бол;

2/тухайн этгээд нь хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрээс чөлөөтэй гарах бололцоотой болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор гараагүй бол, энэ хугацаанд тухайн этгээдийн өөрөөс үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас хүсэлт гаргагч Талын нутаг дэвсгэрээс гарч чадаагүй хугацааг оруулан тооцохгүй.

18 дугаар зүйл

Дамжин өнгөрүүлэх

1.Аль нэг гуравдагч улсаас аль нэг Талд шилжүүлэн өгч буй этгээдийг нөгөө Талын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлбэл тухайн этгээдийг шилжүүлэн авч буй Тал нөгөө Талын нутаг дэвсгэрээр түүнийг ийнхүү дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл авна. Харин хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрт буулгүйгээр агаарын тээврийн хэрэгсэл ашиглан дамжин өнгөрүүлэх бол ийм

зөвшөөрөл авах шаардлагагүй.

2.Дамжин өнгөрүүлэх хүсэлт нь хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжид харшлахгүй бол хүсэлт хүлээн авагч Тал дамжуулан өнгөрүүлэх зөвшөөрөл олгоно.

19 дүгээр зүйл

Үр дүнг мэдэгдэх

Хүсэлт гаргагч Тал нь шилжүүлэн авсан этгээдийг эрүүгийн хариуцлагад татсан буюу түүнд оногдуулсан ял шийтгэлийг биелүүлсэнтэй холбогдсон, эсхүл түүнийг гуравдагч улсад дамжуулан шилжүүлсэн талаархи мэдээллийг хүсэлт хүлээн авагч Талд цаг тухайд нь мэдэгдэнэ.

20 дугаар зүйл

Зардал

Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхтэй холбогдон гарсан зардлыг уг зардал гаргагч Тал хариуцна. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөхтэй холбогдсон тээврийн болон дамжин өнгөрүүлэх зардлыг хүсэлт гаргагч Тал хариуцна.

21 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлах явцад гарч болох аливаа маргааныг Талууд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

22 дугаар зүйл

Бусад гэрээтэй холбогдох нь

Энэхүү Гэрээ нь Хэлэлцэн тохирогч Талуудын бусад гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн аливаа эрх, үүргийг хөндөхгүй.

23 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1.Энэхүү Гэрээг соёрхон батлах бөгөөд соёрхон баталсан тухай Батламж жуух бичгүүдийг Бээжин хотноо солилцоно.

2.Энэхүү Гэрээ нь Батламж жуух бичгүүдийг солилцсон өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

3.Энэхүү Гэрээ хугацаагүй бөгөөд аль нэг Талд дипломат шугамаар, Гэрээг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдсэнээс хойш 6 сар өнгөрмөгц энэхүү Гэрээний үйлчлэх хугацаа дуусгавар болно. Ийм мэдэгдэл гаргах нь түүнээс өмнө эхэлсэн аливаа шилжүүлэн



өгөх үйл ажиллагаанд нөлөөлөхгүй.

Дээрхийг нотлон тус тусын Засгийн газраас албан ёсоор эрх олгогдсон доорхи хүмүүс энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү Гэрээг Улаанбаатар хотноо 1997 оны наймдугаар сарын 19-ний өдөр хятад, монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД

АРД УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ